



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/М

Баянсайр

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн улсын үзлэг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг 2022 оны 09 дүгээр сарын 21 -ны өдөр зохион байгуулсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Ариунаа (Сумын Үйлдвэрчний эвлэлийн дарга)

Гишүүн: Б.Отгонжаргал (сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Э.Батцэцэг (Сумын хөдөлмөр эрхлэлт халамжийн

асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Үзлэгийг сумын эрүүл мэндийн төвд хийж, батлагдсан удирдамж, маягтын дагуу хариуцлагатай зохион байгуулж, үр дүнг танилцуулж, дүгнэлт, саналын хамт Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Газарт хүргүүлж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Ариунаа) -д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Бямбаням)-д даалгасугай.

ДАРГА

С. ЭНХТӨР



642101499